



Хувь хүний нууцыг хадгалах тухай журам Нууцлалын бодлого

Бид энэхүү хувь хүний нууцыг хадгалах тухай журмаар Нууцлалын бодлогоор дамжуулан (цаашид "Журам" гэх) Qualcomm компани болон түүний салбарууд (хамтад нь "бид", "бидний", "манай" гэж нэрлэсэн) нь таны мэдээллийг ямар хүрээнд, хэрхэн цуглуулж, боловсруулж, ашиглан, бусдад дамжуулдаг талаар тодорхой мэдээлэл хүргэсэн болно. Qualcomm компани болон манай салбарууд нь дэлхий даяар аж ахуй нэгжүүд (хуулийн этгээд), бизнесийн үйл ажиллагаа болон мэдээллийн системүүдэд өөрсдийн удирдан хянаж байгаа өгөгдөл мэдээллийг тодорхой хэмжээнд дамжуулж байдаг. Иймд энэхүү журмын хэмжээнд бид "хувийн мэдээлэл" нэр томъёог холбогдох бүх хууль дүрэм журмыг хамааруулах үүднээс ашиглаж байна. "хувийн мэдээлэл" нь аливаа хүнтэй холбоотой мэдээлэл эсвэл дангаараа, бусад мэдээлэлтэй хамт тэрхүү хүнийг тодорхойлох боломжтой мэдээллийг хэлнэ.

Хамрах хүрээ

Журам нь манай цахим хуудас, бүтээгдэхүүн, үйлчилгээ эсвэл шууд эх сурвалжийг нь байршуулж буй программ зэрэгт хамааралтай. Энэхүү журам нь зөвхөн манай компаниас үзүүлж буй үйлчилгээгээр дамжуулан цуглуулсан мэдээлэлтэй холбоотой бөгөөд үүнд бусад төрлийн мэдээлэл цуглуулах, боловсруулах үйл ажиллагаа, эсвэл өөрсдийн гэсэн хувь хүний нууцын журам бүхий бусад үйлчилгээний мэдээлэл цуглуулах арга ажиллагаа ямар нэгэн хэмжээгээр хамрагдаагүй болно. Бид зарим тохиолдолд энэхүү журмыг судалгаа, Карьер веб хуудас гэх мэт тусгай зориулалт бүхий веб хуудасуудад ашигладаг. Энэ тохиолдолд, журмыг тодорхой анхааруулга болон хувийн мэдээлэл ашиглах зөвшөөрлийн хүсэлт (цуглуулах мэдээллийн төрөл болон мэдээлэл цуглуулж буй зорилготой холбоотойгоор) хэлбэрээр танд хүргэн мэдэгддэг.

Мэдээллийн төрөл, мэдээлэл цуглуулах аргачлал

Бид дор дурдагдсан хэрэгслээр төрөл бүрийн хувийн мэдээллийг цуглуулдаг. Танд бидэнд мэдээллээ өгөх эсэх тал дээр сонголт байдаг. Бид таниас өөрийн хувийн

мэдээллийг өгөхийг хүсэх үед та өгөхгүй байх ч сонголттой. Гэвч та мэдээллээ бидэнд өгөхийг зөвшөөрөөгүй тохиолдолд танд манайхаас ашиглаж байгаа тухайн бүтээгдэхүүн, үйлчилгээ тодорхой хэмжээнд буурах, хязгаарлагдаж болно.

Таны ирүүлэх мэдээлэл. Та биднээс мэдээлэл авах, бүртгүүлэх, бүтээгдэхүүн үйлчилгээ захиалах эсвэл өөр бусад зорилгоор бидэнд мэдээлэл илгээсэн үед бид таны нэр, цахим шуудангийн хаяг, шуудангийн хаяг, утасны дугаар болон таны ажил бизнесийн талаарх мэдээллийг авдаг. Төлбөртэй үйлчилгээтэй холбогдуулан бид мөн таны төлбөрийн мэдээлэл (кредит картны дугаар болон бусад баталгаажуулалтын мэдээлэл), утасны дугаар, нэхэмжлэл гаргах хаяг, хүргэлтийн хаяг зэрэг мэдээллийг цуглуулах шаардлагатай байдаг.

Өөрийн цахим хуудаснуудаас шууд цуглуулах мэдээлэл. Та манай компанийн аль нэг вебсайтад зочлох үед бид таны суурин компьютер эсвэл хөдөлгөөнт төхөөрөмжийн талаар ерөнхий мэдээллийг авдаг. Үүнд таны төхөөрөмжийн ашиглаж буй хайлтын програм хангамж, үйлдлийн систем, IP хаяг болон таны сайтад нэвтэрсэн домэйн нэр зэрэг мэдээлэл багтана. Хэрэв та манай вебсайтад гар утсаараа холбогдож байгаа бол ямар төрлийн гар утас ашиглаж байгаа мэдээллийг ч мөн авдаг болно. Түүнчлэн, бид компанийн вебсайтад таны орж байгаа огноо, цаг хугацаа, вебсайтын аль хэсэг рүү түлхүү орж байгаа болон вебсайтын тухайн тодорхой хэсэгт хэр хугацаатай орсон болон вебсайт руу буцсан давтамжийн тоо болон таны хулганы товшилтын бусад өгөгдлүүд зэрэг вебсайт ашиглалтын талаар таны хувийн мэдээллийг цуглуулж байдаг.

Cookies. Бид манай вебсайт, аппликэйшнүүдийг хэрхэн ашиглаж байгаа талаар таны мэдээллийг цуглуулахад күүки, веб бикон болон тэдгээртэй ойролцоо төрлийн технологиудыг ашигладаг. Күүки гэдэг нь жижиг хэмжээний текстэн файл бөгөөд таныг вебсайт руу нэвтрэх үед таны компьютерийн санах ойд хадгалагдан үлддэг. Бид күүкийг вебсайтаа ажиллуулах болон үйлчилгээ үзүүлэхдээ ашигладаг бөгөөд үүний тусламжтайгаар: (1) танд өмнө орсон вебсайтаа дахин ороход мэдээллээ дахин оруулах шаардлагагүйг сануулдаг, (2) таныг вебсайтад ороход зөвхөн танд зориулсан үндсэн сонирхолын контент болон тэдгээртэй холбогдох мэдээллүүдийг түлхүү үзүүлдэг (3) компанид вебсайтын ажиллагааг сайжруулах, судалгаа хийх, контент үйлчилгээг сайжруулах зорилгоор бодит тоон мэдээллийг боловсруулахад, (4) Сайт, болон үйлчилгээний аюулгүй байдлыг хамгаалах зорилгоор ашигладаг.

Түүнчлэн бид веб шинжилгээний хамтран ажиллагч компаниуд, зар сурталчилааны компаниуд, болон зарын сүлжээнүүдэд вебсайт дээрх күүкий болон веб биконд (1x1 пиксель.GIFs болон сурталчилгааны баннер байрлуулах) нэвтрэх эрхийг олгосон байдаг. Жишээлбэл, бид гуравдагч талын сурталчилгааны компаниудыг Интернэтэд бидний өмнөөс сурталчилгаа тавих, манай вебсайтад хандсан бусад компаниудад өөрсдийн сурталчилгаагаа үзүүлэхэд ашигладаг. Эдгээр гуравдагч талын сурталчилгааны компаниуд нь күүкий болон веб биконы тусламжтайгаар манай компани болон бусад хэрэглэгч, үйлчлүүлэгчдээ сурталчилгааны үр дүнг хэмжих, сайжруулахад ашиглаж байдаг. Үүний тулд эдгээр компаниуд нь манай вебсайтад таны орж байгаа өгөгдөл мэдээлэл болон бусад вебсайт руу орж байгаа мэдээллийг тодорхой хугацааны интервалаар авах хэрэгтэй болдог. Энэ төрлийн мэдээлэлд дараах өгөгдлүүд орно: Сурталчилгааны баннер үзсэн цаг, огноо, тэдгээрийн күүкид агуулсан таны өвөрмөц мэдээлэл болох таны ашиглаж байгаа програм хангамж, төхөөрөмжийн IP хаяг зэрэг орно. Бид мөн энэ өгөгдлийг таны илүү их сонирхсон бүтээгдэхүүн, үйлчилгээний талаарх сурталчилгаа мэдээллийг танд хүргэхэд ашигладаг. Хэрэв Та энэхүү үйл ажиллагаа, тусгай сурталчилгааны талаар талаар илүү мэдээлэл хүсч байвад дараах сурвалжид хандана уу [МӨН ЭНЭХҮҮ НИЙТЭЛ](#).

Та төхөөрөмждөө манай компанийн күүкийг хүлээн авахгүй байх боломжтой, гэвч ингэснээр та манай вебсайт дээрх зарим функцүүдийг ашиглах, бидний зүгээс танд санал болгож буй давуу талуудыг бүрэн авах бололцоогүй болж болно. Та өөрийн ашиглаж буй хайлтын системийнхээ "HelpТусламж" цэс рүү нэвтрэн, күүкийн сонголтыг хэрхэн өөрчлөх талаар мэдээлэл авах боломжтой. Дэлгэрэнгүй мэдээллийг манай Күүкий журамтай танилцаж авна уу.

Программ хангамж: Qualcomm Incorporated-ийн охин компаниуд нь зөөврийн төхөөрөмжийн ажиллах хурд, эрчим хүчний хэмнэлт, нууцлал, аюулгүй байдал болон бусад давуу тал олгох зорилготойгоор олон төрлийн программыг зохиодог. Эдгээр програм хангамжийн аппликэйшнээр дамжуулан бид таны байршлын мэдээлэл болон (төхөөрөмжийн чипний сериал дугаар болон олон улсын subscriber ID дугаар гэх мэт) захиалгын бусад өвөрмөц мэдээллүүд, таны төхөөрөмжинд суусан аппликэйшнүүд болон ашиглаж байгаа аппликэйшнүүдийн талаарх мэдээлэл, тохиргооны өгөгдөл болох төхөөрөмжийн үйлдвэрлэгч, загвар, утасгүй сүлжээ хүлээн авагч, үйлдлийн систем, хувилбарын өгөгдөл, програм хангамжийн байгуулалтын өгөгдөл, таны төхөөрөмж дэх чипний ажиллагаа, баттерейн хэрэглээ болон халалтын мэдээллийн талаарх өгөгдлийг цуглуулан авч болно. [Илүү мэдээллийг](#)

Гуравдагч этгээдийн сурвалж: Түүнчлэн бид үйл ажиллагаандаа гуравдагч талын эх сурвалжууд болох мэдээллийн брокер, нийгмийн сүлжээ, бусад түнш байгууллагууд болон төрийн үйлчилгээний эх сурвалжуудаас хэрэглэгчдийн хувийн мэдээллийг авч ашигладаг.

Мэдээлэл цуглуулах зорилго, өгөгдөл мэдээлэл ашиглалт

Бид таны талаарх хувийн мэдээллийг таны зөвшөөрөлтэйгээөөр болон /эсвэл таны ашигладаг бүтээгдэхүүнийг хүргэх шаардлагаар, өөрсдийн үйл ажиллагааг явуулах, гэрээгээр болон хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх, системийн болон хэрэглэгчдийнхээ аюулгүй байдлыг хамгаалах, бусад хууль ёсны эрх ашигаа хамгаалан гүйцэлдүүлэх зорилгоор ашиглан, боловсруулдаг болно. Хувийн мэдээллийг цуглуулан ашиглах зорилгуудаас жишээ дурдвал:

- Мэдээлэл авах хүсэлт, бүтээгдэхүүн үйлчилгээ захиалах хүсэлт гэх мэт таны бидэнд илгээсэн хүсэлтэд хариу өгөх
- Таны хүссэн үйлчилгээг үзүүлэх, удирдан зохион байгуулах, засвар үйлчилгээ явуулан, аюулгүй байдлыг хангах
- Бизнесээ явуулах, сайжруулах, үйлчилгээгээ хэрэгжүүлэх, хамгаалах, системээ сайжруулах, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ хөгжүүлэх болон бусад бизнесийн дотоод зорилгоор ашиглах
- Үйлчилгээний хэрэглэгчдийнхээ хүсэл таашаалыг илүү сайн ойлгох, үйлчилгээний ашиглалтын талаар бодит тоон өгөгдлийг цуглуулах, үйлчилгээ болон вебсайтаа танд илүү ойртуулан хүргэх
- Технологийнхоо талаар танд мэдээлэл хүргэх, бүтээгдэхүүн үйлчилгээний талаар мэдээлэл, мэдээ болон бусад харилцаа холбооны зорилгоор ашиглах
- Энэхүү журамд тодорхойлсон бусад хэрэглэгдэх байдал болон тухайн мэдээллийг цуглуулан авч байгаа хэсгүүдэд

Салбарын холбогдох хууль тогтоомжид заасны дагуу энэхүү зорилгыг хангахад бид өөр төрлийн мэдээллийн эх сурвалжуудаас олон төрлийн өгөгдөл мэдээллүүдийг цуглуулан авч нэгтгэн ашигладаг болно.

Өгөгдөл хадгалан, боловсруулах газрууд

Бид таны өгөгдөл мэдээллийг АНУ болон дэлхий даяарх серверүүддээ хадгалан боловсруулдаг бөгөөд эдгээр серверүүдээс нэр дурдвал Ази, Европийн эдийн засгийн нутгуувд багтдаг. Бид энэхүү журамд зааснаар мэдээллийг дэлхийн аль ч өнцөг буланд хадгалан боловсруулахдаа өгөгдөл мэдээллээ энэхүү журам болон салбарын холбогдох хууль тогтоомжийн дагуу боловсруулагдаж байгаа эсэхийг хянан шалгах арга хэмжээ авч байдаг.

Бид хувийн мэдээллийг европын эдийн засгийн бүс нутгуудаас бусад улс орон руу дамжуулдаг бөгөөд эдгээр улсуудын заримд Европын комиссоос мэдээллийн хамгаалалт хангалттай түвшинд хүрсэн талаар тодорхой шийдвэрүүд нь гараагүй байдаг. Гэсэн хэдий ч бид эдгээр газруудад мэдээллийг дамжуулахдаа олон төрлийн хууль эрх зүйн механизмуудыг давхар ашигладаг болно (таны зөвшөөрөл болон хууль эрх зүйн гэрээ контракт).

Хувийн мэдээллийг задруулах

Бид таны хувийн мэдээлэлд зөвхөн КуалкомQualcomm (салбарууд)-ын хүрээнд нэвтрэх бөгөөд энэхүү журамд заасан зорилгоор таны хувийн мэдээллийг мэдээлэл боловсруулах зорилгоор хамтран ажиллагч компаниуд болох сүлжээний оператор болон гуравдагч талын түншүүдтэй хуваалцдаг. Манай компани бизнесийн хэрэглэгчид, тэдгээрийн ажилтнуудад зориулан сургалт явуулж, бусад төрлийн үйлчилгээг санал болгож байдаг. Ийм тохиолдлуудад, бид тодорхой бизнесийн хэрэглэгчиддээ тэдгээрийн бизнесийн хэрэглээнд нь зориулж манайхаас үзүүлж буй сургалт, бусад төрлийн үйлчилгээтэйгээ холбоотойгоор дээрх мэдээллүүдийг хуваалцдаг. Бид Таны мэдээллийг хууль заасны дагуу эсвэл өөрсдийн болон бусдын хуулиар олгогдсон эрхийг хамгаалах үүднээс, үүгээр хязгаарлагдахгүй, албан есны албан байгууллагад шүүхийн ажиллагатай холбоотойгоор хуваалцана. Бидний зүгээс хэрэв манай компани бодит байдлаар зарагдсан, өөр компанитай нэгдэн нийлсэн, бүтэц зохион байгуулалтын хувьд дахин шинэчлэгдсэн болон шинэчлэгдэх гэж буй тохиолдолд, компанид хадгалагдаж байгаа хувийн мэдээллийг гуравдагч талд дамжуулан, хуваалцах шаардлагатай болж болно. Мөн бид таны зөвшөөрлийн үндсэн дээр таны мэдээллийг гуравдагч талтай хуваалцаж болно.

Таны сонголт

Оруулах/гаргах. Бид цахим шуудангийн сурталчилгаа гэх мэт зарим нөхцөлүүдэд та бүхэнд зарим төрлийн өгөгдөл мэдээлэл цуглуулалт, ашиглалт, хуваалцах технологийг дэмжих эсвэл цуцлах сонголтот боломжуудыг олгосон байдаг. Ийм тохиолдлуудад бид таны сонголтыг хүндэтгэн авч үзэх болно.

Мэдээллийн эрх зүй. Зарим нэг улсын хууль эрхзүйд заасны дагуу Та өөрийн хувийн мэдээллэд нэвтрэх, устгах, хязгаарлах болон бусад үйлдлийг шаардах. [Энд дарж энэхүү эрхүүдтэй танилцана уу.](#)

Бүү дага. Бид одоогоор веб браузер буюу вебийн хайлтын системүүдээс бидэн рүү илгээсэн DNT сигналд хариу өгдөггүй болно. Одоогоор DNT сигналуудыг хэрхэн хөрвүүлэх, вебсайтууд болон тэдгээрийн сигналыг хүлээн авч буй гуравдагч талуудад энэ тал дээр ямар арга хэмжээ авах нэгдсэн шийдэлд хараахан хүрээгүй байна. Гэсэн хэдий ч та веб браузерийнхаа күүки тохиргооны цэс болон тухайн хэсэгт байрших сурталчилгааны хувийн хяналтын тохиргоо гэх мэт хувийн мэдээллийн бүрэн бүтэн байдал, ашиглалтыг хянахад туслах бусад олон төрлийн арга хэрэгслүүдийг ашиглах боломжтой.

Мэдээлэл хадгалалт

Бид таны бүртгэлийг идэвхтэйэкзаунтийг идэвхитэй байх буюу манай үйлчилгээг авч байх бүх хугацаанд хувийн мэдээллийг тань хадгалж байдаг. Бид хувийн мэдээллийг тухайн мэдээллийг анх цуглуулсан зорилго буюу бизнесийн зорилгод хэрэглэгдэхээ больсноос тодорхой хугацааны дараа устгадаг. Гэсэн хэдий ч бид таны хувийн мэдээллийг өөрсдийн хуулиар хүлээсэн үүрэг, маргаан шийдвэрлэх, гэрээний хэрэгжилтийг биелүүлэх зэрэг зорилгоор шаардлагатай хэмжээнд хадгалан, ашиглаж болно.

Аюулгүй байдал

Интернэт дэх мэдээлэл дамжуулалт нь 100 хувь аюулгүй, алдаагүй байна гэдэг боломжгүй зүйл юм. Гэвч бид таны мэдээллийг алдагдах, буруугаар ашиглагдах, зөвшөөрөлгүй хандалт хийгдэх, мэдээлэл задруулах, өөрчлөгдөх болон устгагдахаас хамгаалахын тулд зохих ёсны арга хэмжээнүүдийг авч байдаг. Харин өөрийн нууц үг, хэрэглэгчийн нэрээ аюулгүй хадгалан, хамгаалж, нууц үг, хэрэглэгчийн нэрээ алдагдсан байж болзошгүй нөхцөлд бидэнтэй доор дурдсан холбогдох хаягуудын нэгээр

холбогдон, мэдэгдэж байх нь таны өөрийн үүрэг юм. Компанийн үзүүлж буй үйлчилгээнд өөр бусад этгээд таны хувийн нууц үг, хэрэглэгчийн нэрээр хандаж, зөвшөөрөлгүй ашигласан тохиолдолд бид хариуцлага хүлээхгүй болохыг анхаарна уу.

Хүүхдийн нууцлал

Манай үйлчилгээ нь насанд хүрэгчдэд зориулагдсан. Тиймээс бид хуульд заасны дагуу хүүхдүүдийн хувийн мэдээллийг зориудаар цуглуулдаггүй бөгөөд насанд хүрээгүй хүнийг бидэн рүү хувийн мэдээллээ илгээхгүй байхыг хүсдэг.

Журмын нНэмэлт өөрчлөлт

Манай байгууллага энэхүү Нууцлалын бодлогыгхувь хүний нууцыг хадгалах тухай журмыг хэдийд ч өөрчлөх, сайжруулах, нэмэх, болон журмын аливаа хэсгийг хасах эрхтэй боловч та бүхэнд тухайн нэмэлт өөрчлөлтүүдийг цаг тухай бүрт нь мэдэгдэн, хамгийн сүүлд шинэчлэгдсэн огноог журамд тодорхой заан үзүүлэх болно. Хэрэв журмыг бүхлээр нь өөрчлөх болсон бол бид та бүхэнд 30 хоногийн өмнө зохих ёсны онлайн мэдэгдлийг хүргүүлэн, та бүхнээс хуульд дагуух зохих ёсны зөвшөөрлийг хүсэх болно. Та манай вебсайтад зочлох болон манай үйлчилгээг ашиглаж байгаа тохиолдолд одоогоор хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа энэхүү журмыг хүлээн зөвшөөрч байна гэсэн үг юм. Бид хэрэгчлэгчдээ энэхүү журамтай ойр ойрхон дахин нягтлалж аливаа гарсан шинэ нэмэлт өөрчлөлттэй танилцаж байхыг зөвлөдөг.

Холбоо барих мэдээлэл

Та бидэнд privacy@qualcomm.com хаягаар цахим шуудан илгээх эсвэл Qualcomm Incorporated, Attn. Privacy Counsel, 5775 Morehouse Drive, San Diego, CA 32121 хаягаар захидал бичиж илгээнэ үү.

Хүчин төгөлдөр болсон огноо: 2019 оны 4-р сарын 30

© 2019 Qualcomm Technologies, Inc. болон түүний хамааралтай компаниуд.